



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 122

Улаанбаатар хот

Г “Аудит, үнэлгээ, эрх зүйн дүгнэлт гаргах
болон тайланг хянахад мөрдөгдөх заавар”
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2011 оны 274/240 дүгээр тушаалаар хамтран баталсан “Бизнес үнэлгээний аргачлал”-ын 2.6.6 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Аудит, үнэлгээ, эрх зүйн дүгнэлт гаргах болон тайланг хянахад мөрдөгдөх заавар”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү зааврын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**АУДИТ, ҮНЭЛГЭЭ, ЭРХ ЗҮЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ БОЛОН
ТАЙЛАНГ ХЯНАХАД МӨРДӨГДӨХ ЗААВАР**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү заавар нь аудит, үнэлгээ, эрх зүйн дүгнэлт гаргахад мөрдөгдөх чиглэлийг тодорхойлж, Хорооны зүгээс дүгнэлтийг хянахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Холбогдох хууль тогтоомж, аудит, үнэлгээний олон улсын стандарт /цаашид “ОУС” гэх/ болон энэхүү зааврын дагуу бэлтгэгдээгүй тайлан, дүгнэлтийг Хороо хүлээн зөвшөөрөхгүй.

1.3. Энэхүү зааварт дурьдагдсан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. “үнэт цаас гаргагч” гэж нийтэд санал болгон хувьцаа, бонд, бусад үнэт цаас гаргахаар эсхүл хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулах, хасуулахаар Хороонд албан ёсоор хүсэлтээ ирүүлсэн этгээдийг;

1.3.2. “аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компани” гэж үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэхээр Хороонд бүртгэгдсэн этгээдийг;

Хоёр. Аудитын үйл ажиллагаа

2.1. Аудитын байгууллага нь үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэхдээ Иргэний тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Аудитын тухай хуулийг мөрдөж ажиллах бөгөөд дор дурьдсан үйл ажиллагааг нэмж гүйцэтгэнэ:

2.1.1. үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлан, Хорооноос тогтоосон нэмэлт тодруулга, бусад шаардлагатай санхүүгийн баримт, материалыг шалган баталгаажуулах;

2.1.2. нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлан гаргалт нь Хорооноос гаргасан журам, дүрэмд нийцэж байгаа эсэхийг дүгнэх;

2.1.3. Үнэт цаасны зах зээлийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Хорооноос тогтоосон заавар, журмын хүрээнд нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартын дагуу хөтлөх, нэвтрүүлэх, нягтлан бодох бүртгэлийн бодлого боловсруулахад туслах, зөвлөх;

2.1.4. үнэт цаас гаргагч компанийн дотоод хяналтын журам холбогдох хууль тогтоомж, стандартад нийцэж байгаа эсэхийг хянах, дотоод хяналт нь журмын дагуу хийгдэж байгаа эсэхэд дүгнэлт өгч, зохистой дотоод хяналт хэрэгжүүлэхэд нь туслах;

2.1.5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг биелүүлж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт гаргах;

2.1.6. үйлчлүүлэгчийн төлбөрийн чадвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхид үнэлэлт дүгнэлт гаргах;

2.1.7. үйлчлүүлэгчийн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, ажлын капиталын хэрэгцээ, хангамж, санхүүгийн хувьд Хорооноос тогтоосон нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах;

2.1.8. ногдол ашиг хуваарилалт, олголт, зээл авалт, төлөлтийн байдал, хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэл байгаа эсэх, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрэх нөхцөл байгаа эсэхийг хянах;

2.1.9. шалгалтад хамрагдаж байгаа хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдсэн эсэхийг хянаж, хийгдсэн бол Компанийн тухай хуульд заасан журмын дагуу эсэхийг шалгах;

2.1.10. үнэт цаас гаргагч нь охин, хараат, зэрэгцээ болон толгой компани байгаа эсэх талаар тодруулга хийж, холбогдох дүгнэлт өгөх;

2.2. Аудитор нь аудитын үйл ажиллагаанд аудитын олон улсын болон үндэсний стандартыг мөрдөнө.

2.3. Аудитын байгууллага нь үйлчлүүлэгч байгууллагын санхүүгийн тайлан, шалгалттай холбогдох баримтад шалгасан аудиторын хувийн тэмдэг дарах бөгөөд өгсөн зөвлөмж, дүгнэлтийг аудитын байгууллагын захирлын гарын үсэг, байгууллагын тамга тэмдэгээр баталгаажуулан Хороонд ирүүлнэ.

2.4. Аудитын байгууллага нь үйлчлүүлэгчийн баримт материалд үндэслэн гаргасан дараах дүгнэлтийн талаар Хороонд нэн даруй мэдэгдэнэ:

2.4.1. Компанийн тухай хуулийн 31.3-т заасан нөхцөл байдал бий болсны улмаас тухайн компани төлбөрийн чадваргүй болсон эсхүл болж болзошгүй;

2.4.2. сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг хууль зөрчин хийсэн буюу хийсэн байж болзошгүй;

2.4.3. санхүүгийн онц хүндрэлтэй байдалд орж болзошгүй болсон;

2.4.4. хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг зөрчсөн;

2.4.5. Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооноос баталсан журмыг зөрчсөн;

2.4.6. Хорооноос тогтоосон нийтэд хүргэх мэдээлэлд тусгагдсан үзүүлэлт нь санхүүгийн тайланд тусгагдсан мэдээллээс зөрүүтэй болох нь тогтоогдсон;

2.4.7. Холбогдох хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн.

2.5 Аудитын дүгнэлт нь зохих зөвлөмжөөр заавал дэмжигдсэн байна.

Гурав. Үнэлгээний үйл ажиллагаа

3.1. Үнэлгээний байгууллага нь Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, холбогдох стандарт, арга, аргачлал, журмыг мөрдөх бөгөөд Үнэт цаас гаргагчтай холбоотой үнэлгээ хийхдээ дор дурдсан зааврыг мөрдөнө.

3.1.1. тухайн компанийн болон тухайн салбар, орон нутгийн макро эдийн засгийн холбогдох мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийх;

3.1.2. уул уурхай, эрдэс баялгийн салбараас бусад салбарын компани хэлбэрээ өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болж байгаа тохиолдолд тус компанийн бизнесийг цэвэр хөрөнгийн болон зах зээлийн жишиг хандлагын аргын аль ихээр үнэлж, хяналттайн нэмэгдүүлэг, хяналтгүйн хорогдуулга хийхгүй байх;

3.1.3. шинээр болон нэмж хувьцаа гаргаж байгаа тохиолдолд ирээдүйд олох орлого нь ямар нэг байгалийн нөөц эсхүл урт хугацааны гэрээ хэлцэл, үндэслэлтэй тооцоо судалгаагаар баталгаажуулахгүй нөхцөлд орлогын хандлагын аргыг ашиглахгүй байх;

3.1.4. шинээр болон нэмж хувьцаа гаргаж байгаа тохиолдолд бизнесийн үнэлгээг хөрөнгө оруулалт хийхээс өмнөх болон хийсний дараах 2 үеэр хийж ирүүлэх;

3.1.5. ижил төрлийн хөрөнгөд адил арга, аргачлал хэрэглэх;

3.1.6 үнэлгээчин нь нарийн мэргэжил, технологийн холбогдолтой асуудал дээр тухайн салбарт мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, дадлага туршлага, нэр хүнд бүхий мэргэжилтний туслалцааг авах;

3.1.8. бизнес төлөвлөгөөн дээр үндэслэсэн орлогын хандлагаарх үнэлгээ нь тухайн компанийн үйл ажиллагаа явуулж байгаа салбарын дундажаас хэт зөрүүтэй биш байх, хэрэв тооцоолол хэт зөрүүтэй гарсан бол тайлбар, тодруулга үнэлгээний тайланд хавсаргаж ирүүлэх;

3.2. Хөрөнгийн үнэлгээний болон бизнесийн үнэлгээний тайлангууд нь хавсралт, холбогдох баримт бичгүүдээс гадна сүүлийн 3 жилийн аудитын дүгнэлтээр (зөвлөмжийн хамт) дэмжигдсэн байна.

3.3. Үнэлгээний тайлан нь энэ журмаар тогтоосон загварын дагуу бэлтгэгдсэн хавсралтуудын хамт хэвлэмэл болон цахим хэлбэрээр Хороонд хүргэгдэнэ. Үнэлгээний тайланд хэрэглэгдэх хавсралтууд нь энэ журмын Хавсралт №2 (Барилга байгууламжийн талаарх мэдээлэл), Хавсралт №3 (Тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл), Хавсралт №4 (Биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл), Хавсралт №5 (Мал амьтдын талаарх мэдээлэл), Хавсралт №6 (Авлага, өр төлбөрийн үнэлгээний жагсаалт)-ийн дагуу бэлтгэгдэнэ. Эдгээр хавсралтуудыг Хороо үнэлгээний мэдээллийн сан бүрдүүлэхэд ашиглана.

Дөрөв. Хуулийн компаниас хэрэгжүүлэх хяналтын үйл ажиллагаа

4.1. Хуулийн компани нь эрх зүйн дүгнэлт гаргахтай холбогдсон хоёр талын эрх үүргийг тусгасан гэрээг үйлчлүүлэгчтэй байгуулах бөгөөд Хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 2.2.3-д заасан үйл ажиллагаануудад дүгнэлт гаргана.

4.2. Хорооны шаардлага, нийтэд санал болгон үнэт цаас гаргасан болон зах зээлийн мэргэжлийн компанийн хүсэлтээр аливаа гэрээ, дүрэм, журмыг хянан, хуульд нийцүүлэн нэмэлт үйлчилгээ үзүүлж болно.

Тав. Аудит, үнэлгээ, эрх зүйн дүгнэлтийн иж бүрдэл

5.1. Бүртгэгдсэн этгээдээс үнэт цаас гаргах танилцуулга, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлан, үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, бусад үйл ажиллагааны талаар гаргасан дүгнэлтийг Хороо хүлээн авахдаа тус тайлангуудыг гаргахад хэрэглэгдсэн, тайлангийн үр дүнд шууд нөлөөлөх, гол дэмжих бичиг баримтууд болон аудитын зөвлөмж, техник эдийн засгийн үндэслэл, үнэлгээний тайлангийн цахим хувилбар зэргийг хамтад нь хүлээж авна.

5.2. Энэ зааврын 5.1-д тусгагдсан бичиг баримт дутуу эсвэл холбогдох шаардлагуудыг хангаагүй тохиолдолд тайлан, дүгнэлтийг хянахгүй байх үндэслэл болно.

Зургаа. Тайлангийн чанарын хяналт

6.1. Үнэт цаас гаргагчтай холбоотой хийгдсэн аудит, үнэлгээний тайлан, дүгнэлтэд тусгагдсан тоо, мэдээллийн эх үүсвэр, аргачлал, тооцооны үндэслэлийг Хорооны Эрсдэлийн

үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний газар, хуулийн дүгнэлтийн үндэслэлийг Эрх зүйн хэлтэс тус тус хянана.

6.2. Үнэлгээний тайлангийн хяналтыг энэхүү зааврын Хавсралт 1 дэх зөвлөмж хүснэгтэд, Аудитын тайлангийн хяналтыг аудитын тайланд хавсаргасан зөвлөмж болон бусад холбогдох бичиг баримтуудад тус тус үндэслэн хийх бөгөөд Хорооны 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 209 дүгээр тогтоолоор батлагдсан “Аудитын чанарын хяналтын түр журам”-ын дагуу нарийвчлан шалгана.

6.3. Үнэт цаас гаргагчтай холбоотой хийгдсэн аудит, үнэлгээ, эрх зүйн тайлан, дүгнэлтийн үндэслэлийн талаар бүртгэгдсэн этгээдээс Хороо нэмэлт тайлбар авч болно.

6.4. Ирүүлсэн тайлбар шаардлага хангаагүй бол харъяалагдах мэргэжлийн холбоод дахь маргаан таслах мэргэжлийн зөвлөлд хандаж болно.

Үнэлгээний тайланг хянах зөвлөмж хүснэгт

Үнэлгээний ажлыг гүйцэтгэсэн этгээд:

Үнэлгээний ажлын захиалагч:

Үнэлгээний ажлын зорилго:

Д.д	Үнэлгээний тайланг хянах шалгуур үзүүлэлтүүд	Шаардлага хангасан эсэх, хангаагүй бол тайлбар
1	Хорооны бүртгэгдсэн этгээд гүйцэтгэсэн эсэх, жагсаалтад байх шалгууруудыг энэ үнэлгээ хийх өдрөөр хангаж буй эсэх	
3	Үнэлгээний тайлангийн иж бүрдэл хангагдсан эсэх	
4	Үнэлгээний багийн ахлагчийн баталсан төлөвлөгөөний дагуу ажилласан эсэх	
5	Хорооноос баглан гаргасан зааврыг мөрдсөн эсэх	
6	Үнэлгээний цар хүрээг зөв тодорхойлсон эсэх	
7	Хөрөнгийн эрхтэй холбоотой тодорхойлолтуудыг нарийн гаргасан эсэх	
8	Үнэлгээнд хангалттай мэдээлэл ашиглаж, судалгаа хийсэн эсэх. Үүнээс - Дэлхийн болон улс орны эдийн засагтай холбоотой макро түвшний судалгаа хийсэн эсэх - Эдгээр мэдээлэл нь тулгадан шалгагдах боломжтой эсэх - Гуравдагч этгээдийн гаргасан мэдээллийг ашигласан эсэх, ашигласан тохиолдолд үндэслэлийг баталгаажуулсан эсэх	

“Аудит, үнэлгээ, эрх зүйн дүгнэлт гаргах болон тайланг хянахад мөрдөгдөх заавар”-ын 2 дугаар хавсралт

Барилга, байгууламжийн үнэлгээний жагсаалт

д	Хөрөнгийн ден	ашиглагчид орсон он	Анхны үнэ	Хэмжих нэгж	Хэмжээ	цэвэр талбай	хийц бүтэц	Нэгжийн өртөг /мян.төг/	Үнийн өсөлтийн итгэлцүүр	Хийцийн итгэлцүүр	Төхсөн байдлын итгэлцүүр	Барилга байгууламжийн тоо	Шинээр сартсан босгох өртөг /мян.төг/	Нийт ашиглах жил	Биет эзлүүдийн хувь	Эдийн засгийн эзлүүдийн хувь	Бүрүү ашиглалтын хувь	Дүн	Хуримтлагдсан эзлүүл	Цаашид ашиглагдах хугацаа	Шинэчилсэн үнэлгээ	Үнэлгээг тасалбар болгосон он сар өдөр	Үнэлгээ хийсэн он сар өдөр	Байршил	Зориулалт хийц хэсэг марк	Үнэлгээний компанийн нэр
---	---------------	---------------------	-----------	-------------	--------	--------------	------------	-------------------------	--------------------------	-------------------	--------------------------	---------------------------	---------------------------------------	------------------	---------------------	------------------------------	-----------------------	-----	----------------------	---------------------------	--------------------	----------------------------------------	----------------------------	---------	---------------------------	--------------------------

“Аудит, үнэлгээ, эрх зүйн дүгнэлт гаргах болон тайланг хянахад мөрдөгдөх заавар”-ын 3 дугаар хавсралт

Машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслэлийн үнэлгээний жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр төрөл марк																				
		ашигтлагданад орсон он	Анхны үнэ	Хэмжих нэгж	Хэмжээ	Нийт шинээр сэргээж босгох үнэ	Нийт ашиглах жил	Цаашд ашиглах жил	Чанар	Хуримтлагдсан эзлэгдэл	Нэг бүрийн үнэлгээ	Нийт үнэлгээ	Үнэлгээг тасалбар болгосон он сар өдөр	Үнэлгээний компанийн нэр							

“Аудит, үнэлгээ, эрх зүйн дүгнэлт гаргах болон
тайланг хянахад мөрдөгдөх заавар ”-ын 6 дугаар хавсралт

Авлага, өр төлбөрийн үнэлгээний жагсаалт

д/д	Авлага, өгжлөгийн төрөл	Үүссэн огноо	Өөрчлөлт	Тайлбар	Үнэлгээ хийсэн он, сар, өдөр	Үнэлгээний компанийн нэр